

**СЭРГЭЭН ЗАСАХ СУДЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР**  
**МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ТУСГАЙ ШАЛГУУР**

**1. Ахлах зэрэг олгох тусгай шалгуур**

1. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож 2-оос доошгүй удаа илтгэл, хураангуй хэвлүүлж хэлэлцүүлсэн байх
2. Зэрэг горилох мэргэжлийн дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтанд 3 жил тутамд хамрагдсан байх

**2. Тэргүүлэх зэрэг горилох эмч нар дараах “тусгай” шалгуурыг хангасан байна. Үүнд:**

1. Мэргэжлийн ажлаа чадварлаг гүйцэтгэж, эмчилгээ үйлчилгээний дутагдал гаргаагүй нь баталгаажсан байх
2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож 2-оос доошгүй удаа өгүүллэг хэвлүүлж, 4-оос доошгүй удаа илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх
3. Мэргэжлийн холбогдолтой зөвлөмж, гарын авлага 2-оос доошгүй удаа гаргаж, хэрэгжүүлсэн байх
4. Оношлогоо, эмчилгээний шинэлэг арга технологи эзэмшиж, эмнэлзүйн практикт нэвтрүүлэн үр дүнд хүрсэн байх
5. Зэрэг горилох мэргэжлийн дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтанд 3 жил тутамд хамрагдсан байх
6. 2-оос доошгүй удаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон олон нийтэд зориулсан сургалт зохион байгуулсан байх

**3. Зөвлөх зэрэг горилох эмч нар дараах “тусгай” шалгуурыг хангасан байна. Үүнд:**

1. Мэргэжлийн ажлаа чадварлаг гүйцэтгэж, эмчилгээ үйлчилгээний дутагдал гаргаагүй нь баталгаажсан байх
2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож 4-оос доошгүй удаа илтгэл, өгүүллэг хэвлүүлж, 8-оос доошгүй илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх
3. Мэргэжлийн холбогдолтой зөвлөмж, гарын авлага 4-оос доошгүй удаа гаргаж, хэрэгжүүлсэн байх
4. Мэргэжлээрээ зөвлөх, бие даан мэргэжлийн санал дүгнэлт гаргах, сургалт явуулах түвшинд хүрсэн байх
5. Оношлогоо, эмчилгээний шинэлэг арга технологи эзэмшиж, эмнэлзүйн практикт нэвтрүүлэн үр дүнд хүрсэн байх
6. 6-оос доошгүй удаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон олон нийтэд зориулсан сургалт зохион байгуулсан байх
7. 4-оос доошгүй мэргэшигч эмчийг дагалдуулан сургаж, сургалтанд оролцсон байх
8. Гадаадын Олон улсын шинж чанартай хуралд 2-оос доошгүй удаа оролцсон байх